



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/518

Арвайхээр

**Олон нийтийн эргүүлд төрийн алба
хаагчдыг ажиллуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “б”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан иргэдийг Коронавируст халдвар (Covid-19)-аас урьдчилан сэргийлэх, мэдээ, мэдээлэл түгээх, иргэдийн хөдөлгөөнд хяналт тавих, хүн амын эрүүл мэнд, нийгэмд учрах сөрөг үр дагаврыг багасгах зорилгоор “Олон нийтийн эргүүл”-ээр төрийн байгууллагуудын алба хаагчдыг татан ажиллуулсугай.

2.Олон нийтийн эргүүлд ажиллах төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгжийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3.Олон нийтийн эргүүлд ажиллах алба хаагчдад шаардагдах автомашин, шатахуун, хантааз, маск, бээлий, гар ариутгагч зэргийг тухайн байгууллагаас хариуцан, хуваарьт өдөр 4-өөс доошгүй алба хаагчдыг олон нийтийн эргүүлээр ажиллуулахыг байгууллагын удирдлагуудад даалгасугай.

4.Олон нийтийн эргүүлд ажиллах алба хаагчдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга (Цагдаагийн хурандаа О.Ганбат)-д үүрэг болгосугай.

5.Коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх, бүх нийтийн бэлэн байдлын үед олон нийтийн эргүүлээр ажиллах байгууллагуудын ажлын зохион байгуулалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101177

Аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн 1519 дугаар захирамжийн хавсралт



КОРОНАВИРУСТ ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
 ҮҮРЭГ БҮХИЙ ОЛОН НИЙТИЙН ЭРГҮҮЛД АЖИЛЛАХ ТӨРИЙН
 БАЙГУУЛЛАГА, ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ
 АЖ АХУЙН НЭГЖИЙН ХУВААРЬ

№	Байгууллага, аж ахуйн нэгжийн нэр	Ажиллах хугацаа, цагийн хуваарь /10:00-14:00 цаг, 14:00-18:00 цаг/
1	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	2020.11.25
2	Биеийн тамир, спортын газар	2020.11.26
3	Боловсрол, соёл, урлагийн газар	2020.11.27
4	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	2020.11.28
5	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	2020.11.29
6	Орон нутгийн өмчийн газар	2020.11.30
7	Санхүүгийн хяналт, аудитын алба	2020.12.01
8	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	2020.12.02
9	Статистикийн хэлтэс	2020.12.03
10	Татварын хэлтэс	2020.12.04-2020.12.05
11	Улсын бүртгэлийн хэлтэс	2020.12.06
12	Ус, цаг уур, орчны шинжилгээний алба	2020.12.07
13	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	2020.12.08-2020.12.09
14	Хүнс, хөдөө аж ахуйн газар	2020.12.10
15	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	2020.12.11-2020.12.12
16	Шүүхийн шинжилгээний алба	2020.12.13
17	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс	2020.12.14-2020.12.15
18	Мал эмнэлгийн газар	2020.12.16
19	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	2020.12.17
20	Аймгийн Засаг даргын Тамгын газар	2020.12.18-2020.12.19
21	Арвайхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хотын захирагчийн алба	2020.12.20
22	Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газар	2020.12.21
23	Төрийн үйлчилгээний нэгдсэн төв	2020.12.22
24	Онги-Таац голын сав газрын захиргаа	2020.12.23
25	Насан туршийн боловсрол төв, Гэр бүл, хүний хөгжлийн төв	2020.12.24
26	Аймгийн Хөгжимт драмын театр	2020.12.25
27	Аймгийн Музей, Номын сан	2020.12.26
28	Өвөрхангай аймаг дахь Авто тээврийн төв	2020.12.27
29	ӨВ. АЗЗА ТӨХК	2020.12.28
30	ЭБЦТС ТӨХК	2020.12.29
31	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК	2020.12.30
32	Шуудан холбооны газар, Цахилгаан холбоо ХК-ны Өвөрхангай аймаг дахь Холбооны газар	2020.12.31